



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/169

Булган сум

Г Өрхийн эрүүл мэндийн төвийн хөрөнгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 50 дугаар тогтоолын 6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Цоожэд” Өрхийн эрүүл мэндийн төв, “Эмийн цэцэглэн” Өрхийн эрүүл мэндийн төвийн хөрөнгийг Эрүүл мэндийн яамны 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 2/468, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А1/1308 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Эрүүл мэндийн газарт балансаас балансад шилжүүлэх, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар оруулж, шийдвэр гаргуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)  
Гишүүд: Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)  
М.Солонго (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)  
П.Мягмарсүрэн (Эрүүл мэндийн газрын Эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)  
И.Энхжаргал (Эрүүл мэндийн газрын Нягтлан бодогч)  
Л.Лхамсүрэн (Эрүүл мэндийн газрын Нярав)  
Ц.Өсөхбаяр (“Цоожэд” Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)  
Э.Энхжаргал (“Эмийн цэцэглэн” Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)  
Б.Эрдэнэчимэг (“Цоожэд” Өрхийн эрүүл мэндийн

•6326010220

төвийн Нягтлан бодогч)  
Б.Туяа (“Эмийн цэцэглэн” Өрхийн эрүүл мэндийн  
төвийн Нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: С.Оюумаа (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн  
бүртгэл, судалгаа хариуцсан мэргэжилтэн)

2.Хөрөнгийг 2025 оны аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн  
тайлангийн дүнгээр тооллогын ажлыг зохион байгуулж танилцуулахыг Орон нутгийн  
өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР